



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 12 сарын 10 өдөр

Дугаар СХМ-2025/21

Сүхбаатар сум

Орхон сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын
ажлын албаны Санхүүгийн үйл ажиллагаанд
хийсэн хяналт шалгалтын дүн

**Нэг: Хяналт шалгалтын зорилго, хамарсан хүрээ, хугацаа, шалгуулсан
байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалт**

1.1. Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан 2025 оны дугаар 06 дугаар сарын 16-ны өдрийн №10 дугаартай "Санхүүгийн хяналтын ажлын удирдамж"-аар Орхон сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны санхүү төсвийн гүйцэтгэл болон Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиуд болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн актуудын хэрэгжилтийг хянан шалгах, илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт өгөх засаж залруулах зорилготойгоор хяналт шалгалт хийлээ.

1.2. Шалгалтыг Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын Санхүү хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Т.Мөнхзул 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хийж гүйцэтгэлээ.

1.3. Шалгалтад Орхон сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны (цаашид Орхон сумын ИТХ гэх)-ын 2023, 2024 оны санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагааны баримт материал, тайлан тооцоог хамруулав.

1.4. Орхон сумын ИТХ нь улсын бүртгэлийн 3763889 дугаар регистртэй, Төрийн сан дах үндсэн үйл ажиллагааны 100130554001 дугаартай, 100130554401 дугаартай нэмэлт дансыг ашиглаж байна.

1.5. Орхон сумын ИТХ-ын төсвийн орлого, тайлан, төрийн сангийн харилцах дансанд 1-р гарын үсгийг сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Н.Алтаншагай, 2-р гарын үсгийг нягтлан бодогч Л.Сэлэнгэмөрөн нар зурж төсвийн хөрөнгийг захиран зарцуулсан байна.

1.6. Орхон сумын ИТХ нь улс төрийн албан тушаалтан 1, төрийн захиргааны албан хаагч 2 нийт 3 албан хаагч үйл ажиллагаа явуулж байна.

Хоёр. Шалгалтад хамрагдах асуудлууд

2.1 Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт

2.1.1 Сумын ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад санхүүгийн хууль тогтоомжийн хүрээнд УСНББОУС, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдлөг болгон нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулж байгаа боловч тэдгээртэй холбоотой хуулийн тогтоомж зөрчих үйлдэл оршсоор байна.

2.2. Батлагдсан төсөв, гүйцэтгэл зориулалтын дагуу зарцуулсан байдал

2.2.1 Батлагдсан төсөв:

2023 онд орон нутгийн төсвөөс 123,911.1 мянган төгрөгөөр 2024 онд 181,008.8 мянган төгрөгөөр санхүүжихээр төсөв батлагдсанаас 2023 онд 108,237.6 мянган төгрөгийг буюу 87.3 хувийг, 2024 онд 170,054.2 мянган төгрөгийг буюу 93.9 хувийг тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 1

Код	Үзүүлэлт	2023 он			2024 он		
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	хэмнэлт/+/ хэтрэлт -/-	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	хэмнэлт/+/ хэтрэлт -/-
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	123,911.1	108,237.6	15,673.5	181,008.8	170,054.2	10,954.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	123,911.1	108,237.6	15,673.5	181,008.8	170,054.2	10,954.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	108,611.1	101,301.6	7,309.5	146,664.6	143,696.7	2,967.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	85,565.9	80,758.7	4,807.2	115,012.8	114,743.0	269.8
210101	Үндсэн цалин	47,847.1	45,993.0	1,854.1	67,105.7	66,772.7	333.0
210102	Нэмэгдэл	34,718.8	30,442.6	4,276.2	45,507.1	45,641.4	-134.3
210104	Урамшуулал	3,000.0	4,323.2	-1,323.2	2,400.0	2,328.9	71.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,940.9	10,087.6	853.3	15,751.8	14,130.2	1,621.6
210201	Тэтгэврийн даатгал	7,399.9	6,856.6	543.3	9,977.1	9,681.5	295.6
210202	Тэтгэмжийн даатгал	885.3	816.2	69.1	1,158.4	1,029.1	129.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	688.2	654.6	33.6	2,040.3	1,105.5	934.8

210204	Ажилгүйдлийн даатгал	197.0	151.2	45.8	260.0	273.5	-13.5
210205	Эрүүл мэндийн даатгал	1,770.5	1,609.0	161.5	2,316.0	2,040.6	275.4
2104	Хангамж, бараа материалын зардал	4,631.6	4,631.6	0.0	4,000.0	3,666.0	334.1
210401	Бичиг хэрэг	800.0	800.0	0.0	1,200.0	1,206.6	-6.6
210402	Тээвэр, шатахуун	3,000.0	3,000.0	0.0	2,000.0	1,997.4	2.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	713.9	713.9	0.0	800.0	462.0	338.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	117.7	117.7	0.0	0.0	0.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	588.2	0.0	588.2	0.0	0.0	0.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	588.2	0.0	588.2	0.0	0.0	0.0
2107	Томилолт, зочны зардал	2,000.0	1,986.0	14.0	1,300.0	1,280.0	20.0
210701	Гадаад албан томилолт	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
210702	Дотоод албан томилолт	2,000.0	1,986.0	14.0	1,300.0	1,280.0	20.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,696.3	2,058.3	638.1	5,200.0	4,479.4	720.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,588.3	2,058.3	530.1	5,200.0	4,479.4	720.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	108.0	0.0	108.0	0.0	0.0	0.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,188.2	1,779.5	408.7	5,400.0	5,398.2	1.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	588.2	514.7	73.5	4,200.0	4,200.0	0.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,600.0	1,264.8	335.2	1,200.0	1,198.2	1.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,300.0	6,935.9	8,364.1	34,344.2	26,357.5	7,986.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,300.0	6,935.9	8,364.1	34,344.2	26,357.5	7,986.7
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	15,300.0	6,935.9	8,364.1	0.0	0.0	0.0

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.0	0.0	0.0	12,870.0	12,870.0	0.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.0	0.0	0.0	10,540.2	8,755.0	1,785.2
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.0	0.0	0.0	10,934.0	4,732.5	6,201.5
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	123,911.1	108,228.5	15,682.6	181,008.8	170,054.2	10,954.6
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	123,911.1	108,228.5	15,682.6	181,008.8	170,054.2	10,954.6
320001	Орон нутгийн төсвөөс	123,911.1	108,228.5	15,682.6	181,008.8	170,054.2	10,954.6

Төсвийн гүйцэтгэлийн судалгаанаас зарцуулалтыг зардлын ангилал бүрээр шалгаж дүгнэхэд:

- Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал:** нийт төсвийн 2023 онд 85,565.9 мянган төгрөг 2024 онд 115,012.8 мянган төгрөгийг цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд олгохоор төсөвлөснөөс 2023 онд 80,758.7 мянган төгрөгийг зарцуулж 4,807.2 мянган төгрөгийг хэмнэж, 2024 онд 114,743.0 мянган төгрөгийг зарцуулж 269.8 мянган төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.
- Хангамж бараа материалын зардал:** 2023 онд хангамж, бараа материалын зардалд 4,631.6 мянган төгрөг батлагдсанаас бичиг хэргийн зардалд 800.0 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 3,000.0 мянган төгрөг, шуудан, холбоо, интернетийн зардалд 713.9 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зардалд 117.7 мянган төгрөгийг зарцуулж 100%-ийн гүйцэтгэлтэй, 2024 онд хангамж, бараа материалын зардалд 4,000.0 мянган төгрөг батлагдаж бичиг хэргийн зардалд 1,206.6 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 1,997.4 мянган төгрөг, шуудан, холбоо, интернетийн зардалд 462.0 мянган төгрөгийг зарцуулж 334.1 мянган төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.
- Эд хогшил, урсгал засварын зардал:** 2023 онд 588.2 мянган төгрөг батлагдсанаас зарцуулалт хийгдээгүй 588.2 мянган төгрөгийг хэмнэсэн бөгөөд 2024 онд тус зардалд санхүүжилт батлагдаагүй байна.
- Томилолтын зардал:** 2023 онд 2,000.0 мянган төгрөг батлагдаж 1,986.0 мянган төгрөгийг зарцуулж 14.0 мянган төгрөгийг хэмнэсэн, 2024 онд 1,300.0 мянган төгрөг батлагдаж 1,280.0 мянган төгрөг зарцуулж 20.0 мянган төгрөгийг хэмнэж ажилласан байна.
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж:** 2023 онд 2,696.3 мянган төгрөг батлагдсанаас 2,058.3 мянган төгрөг зарцуулж 638.1 мянган төгрөг хэмнэсэн, 2024 онд 5,200.0 мянган төгрөг батлагдсанаас 4,479.4

мянган төгрөгийг зарцуулж 720.6 мянган төгрөгийг хэмнэж БГАҮ-ний зардалд тайлагнасан байна.

6. **Бусад зардал:** 2023 онд 2,188.2 мянган төгрөг батлагдаж 1,779.5 мянган төгрөгийг зарцуулж 408.7 мянган төгрөгийн хэмнэлттэй, 2024 онд 5,400.0 мянган төгрөг батлагдсанаас 5,398.2 мянган төгрөгийг зарцуулж 1.9 мянган төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.
- 6 **Урсгал шилжүүлгийн зардал:** 2023 онд ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшууллын зардалд 15,300.0 мянган төгрөг батлагдсанаас 6,935.9 мянган төгрөгийг зарцуулж 8,364.1 мянган төгрөгийн хэмнэсэн, 2024 онд бусад урсгал шилжүүлгийн зардалд 34,344.2 мянган төгрөг батлагдсанаас төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулалд 12,870.0 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 8,755.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 4,732.5 мянган төгрөг зарцуулж нийт 7,986.7 мянган төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.

2.3. Ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцооллт, олголтын байдал

2023,2024 онуудад сумын ИТХ-ын ажлын албаны цалинг 2 удаа шинэчлэн баталсан байна.

Сумын ИТХ-ын ажлын алба нь 3 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд батлагдсан төсвийн 2023 онд 85,565.9 мянган төгрөг буюу 69 хувь, 2024 онд 115,012.8 мянган төгрөг буюу 64 хувийг цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд олгохоор төсөвлөж 2023 онд 80,758.7 мянган төгрөгийг, 2024 онд 114,743.0 мянган төгрөгийг цалин хөлс болон нэмэгдэл урамшил олгоход зарцуулсан байна.

Ажиллагсдын цалин хөлсний тогтоолт, тооцооллт, олголтын байдлыг хяналт шалгалтын явцад цалингийн дэлгэрэнгүй цэсээс хүн тус бүрийн албан тушаалын ангилал, зэрэглэл, батлагдсан цагийн тооцоо, нэмэгдэл суутгал, тооцох тушаал шийдвэртэй тулган баталгаажуулахын зэрэгцээ НДШ-ийн дэлгэрэнгүй НД8 тайлантай нэг бүрчлэн тулган шалгаж үзэхэд илүү болон дутуу тооцоолж олгосон нөхцөл байдал илрээгүй болно.

2.4. Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдал

Төрийн аудитын байгууллагаас хийсэн хөндлөнгийн хяналт шалгалтаар 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар төсөв санхүү, бүртгэл тайлагналтай холбоотой төлбөрийн акт-1, албан шаардлага-1 хүргэгдсэнийг хэрэгжүүлж ажилласан байна.

Гурав. Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн зөрчил дутагдал

Орхон сумын ИТХ-ын ажлын албаны 2023,2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл хөтлөлт, шатахууны норм, анхан шатны баримтын бүрдүүлэлт хангаагүй, зардлын бүлэг хоорон гүйлгэн зарцуулсан зэрэг дараах зөрчил дутагдал илэрлээ.

Илрүүлэлт 1. Тээврийн хэрэгслэлийн 100 км гүйлтэд зарцуулах норм баримтлаагүй жолоочийн тооцооны хуудасны маяганд явсан заалтыг бичихгүй дутуу бөглөж ажилд гарсан тухай бүрээр нь хөтлүүлээгүй 2024 онд 6,080.0 мянган төгрөгийн шатахуун олгож зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 3.3, 3.6, 6.4 дахь заалтуудыг, Зам тээврийн хөгжлийн сайдын "Жишиг норм батлах тухай" 2019 оны 390 дугаар тушаалаар батлагдсан "Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм" нэгдүгээр хавсралт дахь заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Жолоочийн тооцооны хуудсыг ажилд гарсан тухай бүрд нь километрийн заалтыг бичүүлж шатахууныг сар бүр тооцож тайлагнах зөвлөмж хүргүүлэв.

Илрүүлэлт 2. ИТХ-ын төлөөлөгч нар хуралд суусан ирцийн бүртгэл дутуу, хоолны зардлын төсөв хийгээгүй зардлын тайлан хангалтгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу 1,585.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдлийг үнэн зөв бүрдүүлж баталгаажуулсны үндсэн дээр ажил гүйлгээг бүртгэж санхүүгийн тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэв.

Дөрөв. Дүгнэлт, шийдвэрлэлт:

4.1 Дүгнэлт:

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан удирдамжаар Орхон сумын ИТХ-ын 2023, 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны төсөв, санхүүгийн гүйцэтгэл, бүртгэл тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр "Дунд " эрсдэлтэйд тооцож, төсвийн сахилга бат, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

4.2 Шийдвэрлэлт:

Орхон сумын ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар нийт 6,069.3 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн 1,585.6 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 4,483.7 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлэхээр тус тус шийдвэрлэв.

Тав. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж:

Шалгалтын явцад тус байгууллагын дарга, нягтлан бодогч, шалгалтаар илэрсэн зөрчилд хамаарал бүхий холбогдох албан хаагчтай уулзаж асуулга, тодруулга авч Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулсан болно.

Шалгалтаар илэрсэн зөрчилт үйлдлүүд нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл болох тул холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг ханган ажиллах шаардлагатай байгааг тус сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга, нягтлан бодогч нарт танилцуулж, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа.

Санхүүгийн хяналт шалгалтын тэмдэглэлд тусгагдсан зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийн тайланг нотлох баримтын хамт 2026 оны 05 дугаар сарын 30-ны дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт албан бичгээр ирүүлэхийг тус сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга, нягтлан бодогч нарт даалгав.

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД
АУДИТЫН ГАЗРЫН САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН АХЛАХ
БАЙЦААГЧ



Э.МӨНХЗУЛ

ТАНИЛЦСАН:

ОРХОН СУМЫН ИТХ-ЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Н.АЛТАНШАГАЙ

НЯГТЛАН БОДОГЧ



Л.СЭЛЭНГЭМӨРӨН